

НЭВТРЭХ ХЭСЭГ

- Багш, ажилтан хэрэглэгч: Сургуулийн админ хэрэглэгчээс бүртгэсэн нэр нууц үгээр системд нэвтрэх бөгөөд зөвшөөрөгдсөн эрхийн түвшний мэдээлэлээ харах, хэвлэх зэрэг тодорхой ажиллах хүрээндээ засвар хийх эрхтэй байна.

СИСТЕМД НЭВТРЭХ

Нэвтрэх нэр

Нууц үг

Энэ компьютерт сануулах

Нэвтрэх

[Нууц үгээ мартсан?](#)

Боловсрол, шинжлэх ухааны яам © 2022

ХЭРЭГСЛҮҮДИЙН ТАЙЛБАР

Байгууллага, сургалттай холбоотой өгөгдлүүдийн бүртгэл мэдээллийг хөтлөхөд ашиглах хэрэгслүүд нь хэрэглэгчийн эрхийн түвшнээс үл хамааран, нийтлэг ижил байна.

Хэрэгсэл	Хэрэгслийн нэр	Гүйцэтгэх үүрэг
	Нэмэх	Мэдээллийг шинээр бүртгэх ажиллагаа нь аль ч цэсээс энэхүү үйлдлээр хийгдэнэ.
	Засах	Мэдээллийг засварлахдаа тухайн мэдээлэл дээр компьютерын хулганаар 2 товших эсвэл тус тэмдэгт дээр дарснаар мэдээллийг засварлах цонх гарчирнэ.
	Устгах	Мэдээллийг устгахдаа энэхүү товчийг ашиглан гүйцэтгэнэ.
 Талбарууд	Талбарууд	Цэс тус бүрд агуулагдаж буй мэдээллийг мөр, баганаар шүүж харах боломжтой.
 Аажимтай хадгалагдана!	Анхааруулга	Шинээр мэдээлэл бүртгэсэн болон засварласан тохиолдолд тухайн бүртгэлээ хадгалах дарснаар мэдээллийн системд бүртгэгдэж, хадгалагдана. Хадгалах дарсны дараагаар дэлгэцний баруун дээд буланд тус анхааруулга гарчирнэ.
	Дахин ачаалах	Хуудсыг дахин ачаалах.
	Хэвлэх	Хуудсыг хэвлэх горим.
	Хадгалах	Хуудсыг EXCEL файлаар татах горим.
	Од	Одоор тэмдэглэсэн талбар бүрийн холбогдох мэдээллийг заавал бүртгэх шаардлагатай.
	Гарах	Системээс гарах.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЦОНХ

Хэрэглэгч өөрийн хандах эрхээр нэвтрэх үед "Хэрэглэгчийн дэлгэц" гарч ирнэ. Энэ дэлгэц нь хэрэглэгчийн цэсийг нэгтгэн харуулдаг.

- Зүүн талын хэрэглэгчийн үндсэн цэсүүд (1) нь хандах эрхийн түвшинээс хамаарч өөр байж болно.
- Үндсэн цэсний сонголтоос хамаарч дэд цэс үүсдэг (2).
- Дэд цэсний сонголтоос хамаарч өгөгдлийн жагсаалт үүснэ (3). Хэрэглэгч эрхийн түвшиний хүрээнд энэхүү өгөгдлийн жагсаалтыг шинээр нэмэх, устгах, засвар хийх, шүүж харах боломжтой байна.

Үйлдэл	Тайлбар
1	Хэрэглэгчийн үндсэн цэс. Энэ цэснээс ямар төрлийн өгөгдөлд хандахаа сонгоно.
2	Үндсэн цэсний дэд цэс. Энэ нь үндсэн цэснээс хамаарч өөрчлөгдөнө. Дэд цэсний урд ">" -тэмдэг байвал доошоо задарч, нэмэлт цэсийг харуулна.
3	Өгөгдлийн жагсаалтыг харуулах хэсэг. Жагсаалтаас сонголт хийж засах, устгах, жагсаалт шинээр нэмэх үйлдэл хийх боломжтой.
4	Жагсаалтыг шүүж харуулах хэсэг. Шүүлтүүрийн утга жагсаалтын төрлөөс хамаарч өөрчлөгдөнө.